

**“ТЭЭВЭР ДАРХАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 04 сарын 29 өдөр

№ 01.

Дархан уул аймаг

“Тээвэр дархан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024.04.29-ны өдрийн 14<sup>00</sup> цагт “Монгол-Алт” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд 151136 ширхэг саналын эрхтэй 4 хувьцаа эзэмшигч оролцлоо. Хурлын ирц 92.5 %-тай байгаа нь компанийн тухай хуулийн шаардлагыг хангаж байх тул хурлыг эхлүүлэв. Хурлын даргаар Ж.Очирсүхийг сонгов.

Хурлын дарга: Хурлын дэгийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал болох:

1. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан
2. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны зардлын төсөв, дарга гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. Ногдол ашиг олгох тухай

Хурлын дотоод журмын дагуу Санхүүгийн тайланг ерөнхий ня-бо Д.Бямбажаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн ажлын тайланг хараат бус гишүүн Д.Чулуун нар танилцуулав.

Хурлын дарга: Эдгээр тайлангуудтай холбоотой асуулт, санал хэлж болно гэв.

Хараат бус гишүүн Д.Чулуун: Компаний санхүүгийн тайлан балансад хөндлөнгийн аудит, хяналт шалгалтын “Далай ван Аудит” ХХК-тай гэрээ байгуулан улирал бүр зөвлөмж авч санхүүгийн тайлан балансаа мэргэжлийн түвшинд гаргаж байгааг тус хороо сайшаан тэмдэглэж байна. Компанийхаа үйл ажиллагааг тогтвортой зөв менежментээр удирдан зохион байгуулах нь компаний үндсэн үүрэг юм. Ийм учраас дан ганц зах худалдааны төвүүдийн түрээслэгчдийн мөнгөн орлогоос гадна өөр орлого олох эх үүсвэрүүдийг давхар судлан ажиллах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй байна.

Хувьцаа эзэмшигч Л.Амарсанаа: Хувиарлагдаагүй ногдол ашиг байгаа тэрний талаар мэдээлэл юу байна?

Компанийн ерөнхий нягтлан бодогч Бямбажаргал: Ногдол ашгийн өглөг нь өөр газар оршин суудаг бидэнтэй харьцдаггүй хувьцаа эзэмшигчид байдаг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороо энэ мөнгийг Монголын Хөрөнгийн Биржид төвлөрүүлэх шаардлага тавьдаг боловч, зохих бичиг баримттайгаа ирвэл ногдол ашгийг нь өгөхөд бэлэн байна.

Хувьцаа эзэмшигч Цолмон: Шинэ дарханд ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа авто сэлбэгийн захыг юу гэж бодож байна вэ? Хувьцаа эзэмшигч М.Оюун: Дарханд яг төвлөрсөн том зах байхгүй учир их нөлөөлөхгүй гэж бодож байна. Харин захын хашаан дотор зам талбайн сайжируулах ажил хийгдэж худалдан авагчдын зогсоол, түрээслэгчдийн зогсоолыг цэгцэлж түгжрэлийг багасгаж зохион байгуулалтыг өөрчлөх ажил хийнэ.

Хурлын дарга: Дараагийн хэлэцэх асуудал ТУЗ-ийн 2024 оны цалин урамшууллын хэмжээг батлах. Та бүхэнд санал хэлэх хүн байна уу? Хувьцаа эзэмшигч Оюун: Байхгүй ээ.

Хараат бус гишүүн: Чулуун Байхгүй.

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай. Хувьцаа эзэмшигч Цолмон: Хуучин гишүүдээр сонгоё гэж ярьж байгаа. Та бүгдэд өөр бодол байна уу? Хувьцаа эзэмшигчид: Байхгүй, Хараат бус гишүүд: Байхгүй.

Ногдол ашиг олгох тухай. Хувьцаа эзэмшигч Оюун: ТУЗ нь хуралдаж ногдол ашиг олгох шийдвэрээ гаргасан. Иймээс нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 300 төгрөгөөр олгоё. Олгох хугацааг 12 сарын 31-ний дотор гэж үзэж байна. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч М.Цолмон: Дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч Л.Амарсанаа: Дэмжиж байна.


Хурлын дарга: Өөр санал хүсэлт байхгүй бол санал хураалтаа явуулъя. Тооллогын комисс саналын хуудсаа хувьцаа эзэмшигчдэд тараана уу. Санал хураалт явагдаж дүнг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга Л.Энхсайхан танилцуулж, комиссоос гарах тогтоолоо танилцууллаа.


Хурлын дарга: Тооллогын комиссыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах тогтоолуудыг гаргахаар болж байна Та бүхэнд танилцуулъя.

Үүнд:

1. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан,
2. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны зардлын төсөв, дарга гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. Ногдол ашиг олгох тухай


Хурлын дарга: Хувьцаа эзэмшигч та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье. Хурал 16:30 цагт өндөрлөж байна.

Тэмдэглэл хөтөлсөн:  
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:  / Э.Жавхлантөгс /

Хурлын дарга:  / Ж.Очирсүх /

Хувьцаа эзэмшигч:  / М.Цолмон /

/ М.Оюун /

Хараат бус гишүүн:  / Д.Чулуун /